



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/41

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 4 дүгээр зүйлийн 4.1.8, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, аймгийн төвөөс алслагдсан хөдөөгийн малчдад "Молор" телевиз болон тусгай дугаарын утсаар мэдээлэл хүргэх зардалд 975 000 /Есөн зуун далан таван мянган/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

Хоёр Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

Гурав. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2017 оны  
... дугаар сарын ... өдрийн ...  
... дугаар захирамжийн хавсралт



Зардлын тооцоо

№	Зардлын зүйл	Нэг бүрийн үнэ	Давталт	Нийт үнэ /төгрөг/
1	Молор телевиз	100.000	6	600.000
2	Тусгай дугаар	25	15.000	375.000
				975.000